



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/682

Мөрөн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар тогтоол, 2024 оны 131 дүгээр тогтоол, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXII хуралдааны 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний тодотголд тусгагдсаны дагуу шинээр газар эзэмшиж байгаа 4192624 төлөвлөлтийн нэгж талбарын дугаартай газрыг “Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар” (РД:4142888)-ийн хүсэлтийн дагуу тус байгууллагад Мөрөн сумын 13 дугаар багт байршилтай 10700м<sup>2</sup> газрыг төрийн захиргааны байгууллагын зориулалтаар 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.


2.Уг захирамжаар газар эзэмшиж байгаа хуулийн этгээд “Хөвсгөл аймгийн мал эмнэлгийн газар” (РД:4142888)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712012100